

ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХЭД ХАЛДАХ ЗӨВШӨӨРЛИЙН ТОГТОЛЦОО

Л.Галбаатар

Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан хүний халдашгүй байх эрхэд халдах өнөөгийн тогтолцоо оновчтой эсэх, түүний үндэслэл, зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд нийцэж буй байдал, тэрхүү тогтолцоог хэрхэн өөрчлөх шаардлагатай талаар холбогдох дүн шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргаснаа энэхүү “Бодлогын асуудал”-аар дамжуулан олон нийтийн хүртээл болгож байна. Судалгааны дэлгэрэнгүй тайланг www.forum.mn хаягаар үзнэ үү.

НЭГ. ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТЫН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ТАЙЛБАР

Монгол Улс “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-д 1968 оны 1 дүгээр сарын 5-нд гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-нд соёрхон баталсан.¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль

тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус заасан.² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд хүний халдашгүй байх эрхийг “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хүн бүр

¹ United Nations. Office of the United Nations High Commissioner for Human Rights. Status of Ratification Interactive Dashboard <https://indicators.ohchr.org/>

² Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992 он, №01



Л.ГАЛБААТАР

Хуульч, судлаач Л.Галбаатар нь Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг 2011 онд олон улсын эрх зүйч мэргэжлээр төгссөн бөгөөд 2014 онд Сингапур Улсын Оюуны өмчийн академид оюуны өмчийн эрх зүй, 2017 онд ОХУ-ын Үндэсний судалгааны их сургуулийн Мэдээллийн технологи, оюуны өмчийн олон улсын лабораторид цахим эрх зүйн чиглэлээр тус тус суралцаж төгссөн. Тэрээр цахим эрх зүйн чиглэлээр 4 ном, 18 өгүүлэл, Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр эрдэм шинжилгээний 44 өгүүлэл, нийтлэл хэвлүүлжээ. Түүний эрдэм шинжилгээний бүтээлүүд *Web of Science*, *Scopus* зэрэг эрдэм шинжилгээний тэргүүлэх мэдээллийн санд бүртгэлтэй. Тэрээр 2019 оноос Монголын Хуульчдын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, 2020 оноос Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр ажиллаж байна.

тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж зохицуулсан.³ Энэ заалтыг 1988 онд НҮБ-ын Хүний эрхийн хорооны 32 дугаар хуралдаанаар баталсан Ерөнхий зөвлөмжид дараах байдлаар тайлбарлажээ.⁴

- Хорооны үзэж буйгаар энэхүү халдашгүй чөлөөтэй байх эрх нь төрийн эрх бүхий байгууллага, хувь хүн, хуулийн этгээд зэрэг хэн бүхнээс дур зоргоор, хууль бусаар халдахаас хамгаалсан баталгаа юм. Энэхүү баталгааг бүрдүүлэхийн тулд төрөөс хууль тогтоомж батлах, бусад үр дүнтэй арга хэмжээ авах үүрэгтэй.
- “Хууль бус” гэдэг нь хуульд зааснаас бусад тохиолдолд хөндлөнгөөс оролцох боломжгүй гэсэн үг юм. Улс орнуудын зөвшөөрөгдсөн хөндлөнгийн оролцоо нь зөвхөн Пактын заалт, зорилго, зорилтод нийцсэн хуулийн үндсэн дээр явагдаж болно. Хорооны үзэж байгаагаар “хөндлөнгөөс дур мэдэн оролцох” ойлголт нь хуульд заасан хөндлөнгийн оролцоонд мөн хамаарна. Хуульд заасан үндэслэлтэй байх нь халдашгүй байх эрхэд халдах бүх халдлагыг зөвтгөхгүй бөгөөд тийнхүү халдах тохиолдол бүрийг зайлшгүй байсан эсэхэд үндэслэж дур зоргоороо авирласан эсэхийг тогтооно.
- Хууль ёсны хөндлөнгийн оролцоо нь Пактад нийцсэн байсан ч холбогдох хууль тогтоомжид тэрхүү хөндлөнгөөс оролцох боломжтой нөхцөл байдлыг нарийвчлан зааж өгөх ёстой. Ийм эрх бүхий хөндлөнгийн оролцоог зөвхөн хуульд заасан эрх бүхий байгууллага хэрэг тус бүрийн хүрээнд шийдвэрлэнэ.
- Эрх бүхий төрийн байгууллага хүний хувийн амьдралтай холбоотой мэдээллийг зөвхөн Пактад заасны дагуу нийтийн ашиг сонирхолд зайлшгүй шаардлагатай болох нь тодорхой нөхцөлд гаргуулж авч болно.

- Захидал харилцааг хүлээн авагчид хүргэхээс өмнө хөндлөнгөөс олж авахгүй байх, нээх эсвэл бусад хэлбэрээр уншихгүй байх ёстой.
- Утас, телефон, бусад хэрэгслээр дамжих харилцан яриаг хөндлөнгөөс сонсох, бичлэг хийх зэргээр цахим болон бусад хэлбэрээр тагнахыг хориглоно.
- Хүний гэрт нэгжлэг хийх нь шаардлагатай нотлох баримтыг хайхаар хязгаарлагдах бөгөөд түүнд дарамт шахалт үзүүлэхийг зөвшөөрөх ёсгүй.
- Хувь хүнд болон бие махбодод үзлэг, нэгжлэг хийх нь зайлшгүй шаардлагатай нөхцөлд хийгдэх бөгөөд ингэхдээ хүний нэр төрийг гутаах ёсгүй. Хүний биед үзлэг, нэгжлэг хийх төрийн албан тушаалтан, эсхүл төрийн байгууллагын хүсэлтээр ажиллаж байгаа эмнэлгийн ажилтан нь тухайн хүнтэй зөвхөн ижил хүйстэй тохиолдолд тийнхүү үзлэг, нэгжлэг хийж болно.
- Төрийн байгууллага, хувь хүн, байгууллага эсэхээс үл хамааран компьютер, өгөгдлийн төхөөрөмж болон бусад төхөөрөмж дээр хувийн мэдээллийг цуглуулах, хадгалахыг хуулиар зохицуулах ёстой.
- Хүний хувийн амьдралтай холбоотой мэдээллийг хүлээн авах, боловсруулах, ашиглах, хуулиар зөвшөөрөөгүй хүмүүсийн гарт хүргэхгүй байхын тулд улс орнууд үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд эдгээр нь хэзээ ч Пакттай үл нийцэх зорилгоор ашиглагдах ёсгүй. Хувь хүн бүр түүний файлыг төрийн захиргааны байгууллага, хувь хүн, байгууллага хянаж буй эсэх, эсвэл хянах боломжтой эсэхийг тогтоолгох боломжтой байх ёстой. Хэрэв эдгээр файл нь хувийн алдаатай мэдээллийг агуулсан, хуульд заасныг зөрчиж цуглуулсан, боловсруулсан бол хүн бүр түүнийг засуулах, устгуулах хүсэлт гаргах эрхтэй.

³ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966

⁴ Human Rights Committee. Thirty second session (1988). General comment No. 16: Article 17 (Right to privacy) https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2fCCPR%2fGEC%2f6624&Lang=en

ХОЁР. ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХИЙГ ЗӨРЧСӨН ТУХАЙ ГОМДЛЫГ НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХОРОО ХЯНАН ХЭЛЭЛЦЭЖ, ШИЙДВЭРЛЭСЭН НЬ

НҮБ-ын Хүний эрхийн хорооноос холбогдох гомдлыг хянан хэлэлцэж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлийг зөрчсөн гэж дүгнэсэн 100 орчим шийдвэр (1981-2019 оны хооронд) бий.⁵ Эдгээр шийдвэрээс дүгнэж үзэхэд, хүний халдашгүй байх эрхэд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар халдахаас сэргийлэхийн тулд тэрхүү халдлага нь хууль ёсны, зайлшгүй шаардлагатай,

тохиромжтой байх гэсэн гурван шалгуурыг нэгэн зэрэг хангаж байх ёстой. Хүний халдашгүй байх эрхэд халдах зөвшөөрөл нь энэхүү гурван шалгуурыг хангуулах буюу түүний биелэлтэд хяналт тавихад чиглэнэ. Үүнтэй уялдаатайгаар хүний халдашгүй байх эрхэд хуульд заасны дагуу зохих ёсоор халдахад баримтлах хүний эрхийн олон улсын зарчмуудыг дараах хүснэгтэд заасан байдлаар тодорхойлж болохоор байна.

Хүснэгт 1. Хүний халдашгүй байх эрхэд хуульд заасны дагуу зохих ёсоор халдахад баримтлах хүний эрхийн олон улсын зарчмууд

№	Зарчмын нэр	Товч утга
А. ХУУЛЬ ЁСНЫ БАЙХ		
1	Хууль зүйн үндэслэлтэй байх	Хүний халдашгүй байх эрхийн аливаа хязгаарлалтыг хуулиар урьдчилан тогтоосон байх ёстой.
2	Хууль ёсны зорилготой байх	Ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай эрх зүйн тэргүүлэх зэргийн ашиг сонирхолд нийцэхүйц хууль ёсны зорилгод хүрэхийн тулд төрийн эрх бүхий байгууллагаас хүний халдашгүй байх эрхэд халдах ажиллагаа явуулахыг гагцхүү хуулиар зөвшөөрнө.
3	Хууль бус халдлагын эсрэг баталгаа, эрх зүйн үр нөлөөтэй хамгаалалт бүрдүүлэх	Улс орнууд төрийн болон хувь этгээдийн зүгээс хууль бусаар хүний халдашгүй байх эрхэд хөндлөнгөөс халдах ажиллагааг гэмт хэрэгт тооцсон хууль тогтоомжтой болсон байх үүрэгтэй.
4	Гомдол гаргах нөхцөлөөр хангах	Хүний халдашгүй байх эрхэд хөндлөнгөөс халдах ажиллагаанд өртөж буй хувь этгээдэд тухайн ажиллагааг зөвшөөрсөн шийдвэрийн талаар давж заалдах гомдол гаргах, эрх зүйн бусад өмгөөлөл эрэлхийлэхэд хангалттай байхуйц хугацаанд мэдэгдэх шаардлагатай.
5	Эрх мэдэл бүхий шүүхийн хяналтад байх	Хүний халдашгүй байх эрхэд хөндлөнгөөс халдах ажиллагаатай холбогдох шийдвэрийг эрх бүхий шүүх эрх мэдлийн хараат бус, шударга байгууллага гаргах ёстой.
Б. ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ БАЙХ		
6	Шаардлагатай байх	Хүний халдашгүй байх эрхэд халдах ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн хууль тогтоомж нь хууль ёсны зорилгод тодорхой, үр дүнтэй хүрэхийн тулд маш нарийн тодорхойлсон, зайлшгүй шаардлагатай хэмжээгээр л халдашгүй байх эрхэд халдах ажиллагааны хүрээг тогтооно.
В. ТОХИРОМЖТОЙ БАЙХ		
7	Тохирохуйц байх	Хуулиар тогтоосон хүний халдашгүй байх эрхэд халдах аливаа ажиллагаа нь тодорхой тогтоосон хууль ёсны зорилгыг бүрэн биелүүлэхэд тохирсон байна.
8	Пропорциональ буюу тэнцүү чанартай байх	Хүний халдашгүй байх эрхэд халдах ажиллагаа явуулах тухай шийдвэрт тухайн халдлагын буюу хөндлөнгийн оролцоо нь хүний эрхийг болон бусад эрх ашгийг зөрчих эрсдэлийг харгалзах ёстой.
9	Зүй ёсны ажиллагаа явуулах	Улс орнуудаас хүний эрхэд халдсан аливаа хууль ёсны үйл ажиллагааг хуульд сайтар зүйлчилж, тогтвортойгоор дагаж мөрдөн, олон нийтэд нээлттэй байдлыг хангаснаар хүний эрхийг хүндэтгэн сахин хамгаалахыг шаардана.

⁵ Centre for Civil and Political Rights. Data base and case-law briefs http://ccprcentre.org/database_decisions?page_num=2&filter=1 United Nations. Office of the United Nations High Commissioner for Human Rights. Jurisprudence <https://juris.ohchr.org/Search/Results>

Дээр дурдсан зарчмуудыг нэгтгэн дүгнэж НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас Олон улсын хуульчдын холбоотой хамтран гаргасан шүүгч, прокурор, хуульчдад зориулсан мэргэжлийн сургалтын гарын авлагад “Олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу, хувь хүний халдашгүй байх эрхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр хөндлөнгөөс халдах нь хууль зүйн үндэслэлтэй байх, хууль ёсны зорилготой байх бөгөөд тухайн арга

хэмжээ нь пропорциональ буюу хүний эрхийг хамгийн багаар хөндөхүйц байх ёстой” гэжээ.⁶ Энэ үндсэн дээр хүний халдашгүй байх эрхэд хуульд заасны дагуу халдахад баримтлах хүний эрхийн олон улсын зарчмууд олон салбарт хүлээн зөвшөөрөгдөх болж “Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд баримтлах хүний эрхийн олон улсын зарчмууд”-ыг иргэний нийгмийн байгууллагууд 2015 онд олон нийтийн хүртээл болгожээ.⁷

ГУРАВ. ХҮНИЙ ЭРХИЙН БУСАД ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙГ ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР БАТАЛГААЖУУЛСАН БАЙДАЛ

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд заасан хүний халдашгүй байх эрхийн талаарх заалтыг Хүний эрхийн талаарх Америк хоорондын тусгай бага хурлаас 1969 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр баталж, 1979 оны 7 дугаар 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон Америкийн хүний эрхийн конвенцын 11 дүгээр зүйл, Европын зөвлөлийн гишүүн улсууд 1950 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр баталж, 1953 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон Европын хүний эрхийн конвенцын 8 дугаар зүйлд тус тус адил агуулгаар тусгажээ.⁸

Европын хүний эрхийн конвенцын хэрэгжилтэд Европын хүний эрхийн шүүх хяналт тавьдаг бөгөөд тус конвенцын 8 дугаар зүйлд заасан хувийн болон гэр бүлийн амьдралыг хүндлэх эрхийг зөрчсөн талаарх 4 хэргийг хянан шийдвэрлэжээ.⁹ Эдгээр хүний халдашгүй байх эрхийн талаарх Европын хүний эрхийн шүүхийн голлох шийдвэрийн үндэслэлээс үзэхэд, хүний халдашгүй байх эрхэд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар халдахаас сэргийлэхийн тулд тухайн улсын хувьд боломжит бүх арга хэмжээг даруй авах ёстой бөгөөд ингэж чадаагүй бол тэрхүү халдлага нь хүний эрхийн зөрчил болохыг харуулж байна.

⁶ Office of the High Commissioner for Human Rights in Cooperation with the International Bar Association. Professional Training Series No. 9. Human Rights in the Administration of Justice: A Manual on Human Rights for Judges, Prosecutors and Lawyers. United Nations New York and Geneva, 2003. pp. 229 <https://www.ohchr.org/EN/PublicationsResources/Pages/TrainingEducationtwo.aspx>

⁷ Universal Implementation Guide for the International Principles on the Application of Human Rights to Communications Surveillance. A Product of ACCESS. May 2015. Accessnow.org https://en.necessaryandproportionate.org/files/2016/04/01/implementation_guide_international_principles_2015.pdf

⁸ American Convention on Human Rights http://www.hrcr.org/docs/American_Convention/oashr.html
Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms <https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/005>

⁹ Right to respect for private and family life: landmark judgments <https://www.coe.int/en/web/human-rights-convention/private-life1>

ДӨРӨВ. ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХЭД ХАЛДАХ ЗӨВШӨӨРЛИЙН ТОГТОЛЦООНЫ ХӨГЖИЛ, ӨӨРЧЛӨЛТ

Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдсанаас хойш үйлчилсэн буюу 1963 болон 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд халдашгүй байх эрхэд халдах зөвшөөрлийн тогтолцоог хэрхэн тусгаж байсныг дараах хүснэгтээр авч үзэв. Энд харуулснаар, 1992-2002 он, 2002-2017 он, 2017 оноос хойших хугацаанд хүний халдашгүй байх эрхэд халдах ажиллагааны зөвшөөрлийн тогтолцоо нь харилцан адилгүй байна.

Нийтлэг буюу уламжлагдсаар буй зохицуулалт бол мөрдөгчийн зүгээс халдашгүй байх эрхэд халдах зарим ажиллагааны талаар прокурорт мэдэгдэх, прокуророос зөвшөөрөл авах зохицуулалт юм. 2017 оноос үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд халдашгүй байх эрхэд халдах бүх ажиллагаанд прокурорын зөвшөөрлийг авахаар тусгаснаараа өмнөх хуулиудын зохицуулалтаас дэвшилттэй болжээ. Харин халдашгүй байх эрхэд халдах ажиллагаанд шүүхийн зөвшөөрлийг авахгүй байх зохицуулалт өөрчлөгдсөнгүй.

Хүснэгт 2. Халдашгүй байх эрхэд халдах зөвшөөрлийн зохицуулалт, 1992-2020

Ажиллагаа	Шийдвэр гаргах этгээд			Зөвшөөрөл өгөх этгээд		
	1992-2002	2002-2017	2017-	1992-2002	2002-2017	2017-
1. Хураан авах	Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч	Мөрдөгч	Прокурор	-	Прокурор	
2. Нэгжлэг хийх		Мөрдөгч	Прокурор	-	Прокурор	
3. Хүний биед нэгжлэг хийх		Мөрдөгч	Прокурор	-	Прокурор	
4. Хөрөнгө битүүмжлэх		Мөрдөгч	-	Прокурор	Прокурор	
5. Үзлэг хийх		Мөрдөгч	-	-	Прокурор	
6. Хүний биед үзлэг хийх		Мөрдөгч	-	-	Прокурор	
7. Шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг битүүмжлэх, хураан авах, түүнд үзлэг хийх		Мөрдөгч	Прокурор Шүүгч	Прокурор	Прокурор	
8. Шинжилгээ хийх	Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч	Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх	Шүүх, прокурор, мөрдөгч	-	-	-
9. Хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах	-	-	Мөрдөгч	-	-	Прокурор
10. Орон байр, бусад газарт нэгжлэг хийх	-	-	Мөрдөгч	-	-	Прокурор
11. Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах	-	-	Мөрдөгч	-	-	Прокурор
12. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах	-	-	Мөрдөгч	-	-	Прокурор
13. Харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох	-	-	Мөрдөгч	-	-	Прокурор
14. Хяналт тогтоох	-	-	Мөрдөгч	-	-	Прокурор
15. Ажиглалт явуулах	-	-	Мөрдөгч	-	-	Прокурор

ТАВ. ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХЭД ХАЛДАХ ОДООГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ОЛОН УЛСЫН ЗАРЧМУУДЫН ДАГУУ ШИНЖЛЭХ НЬ

Энэ хэсэгт хүний халдашгүй байх эрхэд хуульд заасны дагуу халдахад баримтлах хүний эрхийн олон улсын зарчмуудыг Монгол Улсын

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт хангаж буй эсэхийг нарийвчлан шинжлэв.

Хүснэгт 3. “Хууль ёсны байх” олон улсын зарчимд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт нийцэж буй эсэх

Олон улсын зарчмууд	Дүн шинжилгээ			
	Үзлэг хийх	Нэгжлэг хийх	Хураан авах, гаргуулах	Хянах, хязгаарлах
1. Хууль зүйн үндэслэлтэй байх	Хуулийн 23.1 зүйлийн 1, 23.2 зүйлийн 1	Хуулийн 24.1 зүйлийн 1, 24.2 зүйлийн 1	Хуулийн 24.4 зүйл, 24.5 зүйл	Хуулийн 26.1 зүйлийн 1, 26.2 зүйлийн 1, 26.3 зүйлийн 1, 26.4 зүйлийн 1
2. Хууль ёсны зорилготой байх	Хүний биед хийх үзлэг нь хүний биед хэргийн ул мөр, онцлог шинж тэмдэг байгаа, эсхүл хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг тухайн хүн биедээ авч яваа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа бол түүнийг илрүүлэх зорилготойг хуульчилсан.	Хэргийн эд мөрийн баримт, бичмэл нотлох баримт, эсхүл эрэн сурвалжилж байгаа хүн, эд зүйл байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг илрүүлэх; хэрэг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий зүйлийг биедээ нууж байна гэх хангалттай үндэслэл байвал түүнийг илрүүлэх зорилгыг хуульчилсан. Хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.25-д “хангалттай үндэслэл” гэж шүүх, прокурор, мөрдөгч энэ хуульд заасан шийдвэр гаргахад нөлөөлж байгаа бодит баримтад тулгуурласан нөхцөл үүссэнийг ойлгоно гэж заасан.	24.4 дүгээр зүйлд эд мөрийн баримт хураан авах, 24.5 дугаар зүйлд мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах зорилгын талаар тусгайлан заагаагүй. Эд мөрийн баримтыг хураан авах ажиллагаанд 24.1, 24.2, 24.3 дугаар зүйлд заасан журмыг баримтална гэсэн нь нэгжлэг хийх, хүний биед нэгжлэг хийх, орон байр, бусад газарт нэгжлэг хийхтэй холбоотой ажиллагааг хамааруулж буй бөгөөд ажиллагааны тусгайлсан зорилгыг илэрхийлэхгүй.	Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах нь гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэхээс сэргийлэх; харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээ, баримтыг цуглуулах, бэхжүүлэх; хяналт тогтоох нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээ, баримтыг тогтоох; ажиглалт явуулах нь эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоох тус тус зорилготой.

3. Хууль бус халдлагын эсрэг баталгаа, эрх зүйн үр нөлөөтэй хамгаалал бүрдүүлэх	15.7 дугаар зүйлийн 1-д зааснаар оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдолд хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаарх гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана.	Эрүүгийн хуулийн 13.7 дугаар зүйл буюу “Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх” гэмт хэрэгт хууль бусаар хүний биед үзлэг хийхийг хамруулаагүй байна.	Эрүүгийн хуулийн 13.7 дугаар зүйлд “Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх” гэмт хэргийг зохицуулсан. Мөн Эрүүгийн хуулийн 13.6 дугаар зүйлд “Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох” гэмт хэргийг зохицуулсан.	Эрүүгийн хуулийн 13.7 дугаар зүйлд зааснаар эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний бие, хүний эд зүйл, тээврийн хэрэгсэлд хураан авсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.	Эрүүгийн хуулийн 13.12 дугаар зүйлийн дагуу эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгөсөн бол хариуцлага хүлээлгэнэ.
4. Гомдол гаргах нөхцөлөөр хангах	22.1 дүгээр зүйлийн 7-д зааснаар мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхлэхээс өмнө оролцох хүнд энэ хуульд заасан эрх, үүргийг тайлбарлах, эрхээ эдлэх боломжоор хангах үүрэг хүлээнэ.	Мөрдөгч эд мөрийн баримт хураан авах ажиллагааг эхлэхийн өмнө хураан авах тухай прокурорын шийдвэрийг танилцуулна.	Мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхлэхээс өмнө оролцох хүнд энэ хуульд заасан эрх, үүргийг тайлбарлах, эрхээ эдлэх боломжоор хангах үүрэгтэй.		
5. Эрх мэдэл бүхий шүүхийн хяналтад байх	22.1 дүгээр зүйлийн 3, 4-т зааснаар үзлэгийг нууцаар хийх бол прокурорын зөвшөөрлийг авах, бусад хэлбэрээр үзлэг хийх бол мөрдөгч бие даан явуулна.	Прокурорын зөвшөөрөлд заасан орон байр, бусад газар, хүний биед мөрдөгч нэгжлэг хийнэ. Мөрдөгч хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр шинжээч, эсхүл мэргэжилтний тусламжтай явуулна.	Мөрдөгч эд мөрийн баримтыг прокурорын зөвшөөрлөөр түр хураан авна. Мөрдөгч шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг шуудан-цахилгаан харилцааны үед нь прокурорын зөвшөөрлөөр хураан авах, эсхүл үзлэг хийж болно.	Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, нууц ажиглалт явуулхад прокурорын зөвшөөрөл шаардлагатай.	

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт нь “хууль зүйн үндэслэлтэй байх”, “гомдол гаргах нөхцөлөөр хангах” дэд зарчимд нийцэж байна. Харин тус хуулийн зохицуулалтыг “хууль ёсны зорилготой байх”, “эрх мэдэл бүхий

шүүхийн хяналтад байх”, Эрүүгийн хуулийн зохицуулалтыг “хууль бус халдлагын эсрэг баталгаа, эрх зүйн үр нөлөөтэй хамгаалалт бүрдүүлэх” гэсэн дэд зарчимд тус тус нийцүүлэх шаардлага байна.

*Хүснэгт 4. “Зайлиггүй шаардлагатай байх” олон улсын зарчимд
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт нийцэж буй эсэх*

Үзлэг хийх	Нэгжлэг хийх	Дүн шинжилгээ	
		Хураан авах, гаргуулах	Хянах, хязгаарлах
Үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хүний биед үзлэг хийх шаардлагыг тусгасан байна. Хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.23-т “үндэслэл бүхий сэжиг” гэж энэ хуульд заасан тодорхой ажиллагаа явуулах нөхцөл үүссэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн талаарх мэдээлэл, хэргийн нөхцөл байдалд тулгуурласан мөрдөгч, прокурор, шүүгчийн дотоод итгэлийг хэлнэ гэжээ.	Дараах үндэслэл байвал прокурорын зөвшөөрөлгүйгээр хүний биед нэгжлэг хийж болно: 1. баривчлах, цагдан хорих арга хэмжээ авахад; 2. хураан авах болон нэгжлэг хийж байгаа орон байр, бусад газар байсан хүн хэрэгт холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг биедээ нууж байна гэх хангалттай үндэслэл байвал.	Хуульд эд мөрийн баримт хураан авах, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах зорилгын талаар тусгайлан заагаагүй тул тэрхүү ажиллагаа нь зайлшгүй шаардлагатай эсэхийг үнэлэх боломжгүй байна.	Үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хянах; шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгах; харилцаа холбооны сүлжээг хянах, хязгаарлах; харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулж авах; орон байранд нэвтэрч, хяналт тогтоох; орон байрнаас бусад газарт нэвтэрч, хяналт тогтоох; тээврийн хэрэгсэлд нэвтэрч хяналт тогтоох; тодорхой нутаг дэвсгэр, олон нийтийн газарт хүн, объектод ердийн болон нууц ажиглалт явуулах ажиллагааг хуульчилсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд бүх төрлийн хэрэг дээр хүний биед үзлэг хийх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, нууц ажиглалт явуулахаар заасан байна. Тодорхой төрлийн

буюу зөвхөн хүнд гэмт хэргээр хязгаарлаж хүний биед үзлэг хийж болох, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, нууц ажиглалт явуулах талаар нарийвчлан зааглах шаардлагатай байна.

Хүснэгт 5. “Тохиромжтой байх” олон улсын зарчимд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт нийцэж буй эсэх

Олон улсын зарчмууд	Дүн шинжилгээ			
	Үзлэг хийх	Нэгжлэг хийх	Хураан авах, гаргуулах	Хянах, хязгаарлах
1. Тохирохуйц байх	Гэмт хэрэг үйлдэгдсэн, үйлдэгдсэн байж болзошгүй гэх бодит үндэслэл байгаа бол мөрдөгч хэргийн нотлох баримтыг олж тогтоох, хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор орон байр, бусад газар, нийтийн эзэмшил газрын тодорхой хэсгийг хэргийн газраар тогтоон үзлэг хийнэ.	Мөрдөгч орон байр, бусад газарт прокурорын зөвшөөрлөөр нэгжлэг хийхэд тухайн газарт нэвтрэх, эсхүл түгжээтэй зүйлийг нээх, шаардлагатай бол хана, тааз болон шалыг салгах, задлах зэрэг ажиллагаа явуулж болно. Тусгай багаж, хэрэгсэл ашиглан хүний биед нэгжлэг хийж болно.	Хуульд эд мөрийн баримт хураан авах, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах зорилгын талаар тусгайлан заагаагүй.	Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, нууц ажиглалт явуулах нь бүх төрлийн хэрэгт хамаарна.

2. Пропорциональ буюу тэнцүү чанартай байх	Хуульд бүх төрлийн хэрэг дээр хүний биед үзлэг хийхээр заасан байна. Тодруулбал, ямар төрлийн хэргийн хувьд хүний биед үзлэг хийх талаар нарийвчлан зааглаагүй.	Нэгжлэг хийхийн өмнө хайж байгаа хүн, эд зүйл, баримт бичгийг сайн дураар заах, гаргаж өгөх боломжийг тухайн хүнд олгоно.	Баримт бичгийг эхээр нь, шаардлагатай бол хууль ёсны эзэмшигчид эхийг нь буцаан олгож, хуулбарыг хэрэгт хавсаргана.	Ажиллагаа явуулах хугацааны талаар тусгайлан заагаагүй бөгөөд зөвхөн прокурорын зөвшөөрөлд ажиллагаа явуулах хугацааны талаар заана.
3. Зүй ёсны ажиллагаа явуулах	Нүцгэлж, эсхүл гараар тэмтрэх байдлаар хийх үзлэгийг ижил хүйсийн албан тушаалтан хийнэ.	Нэгжлэгийг прокурорын зөвшөөрөлд зааснаас бусад зүйлийг илрүүлэх зорилгоор явуулахыг хориглоно. Нүцгэлж, эсхүл гараар тэмтрэх байдлаар хийх нэгжлэгийг ижил хүйсийн албан тушаалтан хийнэ.	Мөрдөгч хураан авах эд мөрийн баримтыг сайн дураар гаргаж өгөх, зааж өгөх боломжийг тухайн хүнд олгоно.	Ажиллагааны явцад хүний эрхийг хангах арга хэмжээний талаар прокурорын зөвшөөрөлд заахаар тусгасан.

Хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг илрүүлэхийн тулд хүний биед үзлэг хийх нь “тохирохуйц байх” зарчмыг алдагдуулж байна. Прокурорын зөвшөөрөлгүйгээр хүний биед нэгжлэг хийж болох нөхцөлийг хуульд тусгасан. Мөн мөрдөгч орон байр, бусад газарт прокурорын зөвшөөрлөөр нэгжлэг хийхэд тухайн газарт нэвтрэх, эсхүл түгжээтэй зүйлийг нээх, шаардлагатай бол хана, тааз болон шалыг

салгах, задлах зэрэг ажиллагаа явуулж болох бөгөөд тийнхүү нэгжлэг хийсний дараа салгасан, задалсан эд зүйлийг өмнөх хэвд нь оруулах буюу сэргээх талаар хуульд заагаагүй. Энэ нь дээрх зохицуулалтыг “хүний халдашгүй байх эрхэд халдах ажиллагаа нь зүй ёсны байх ёстой” гэх зарчимд бүрэн нийцүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

ЗУРГАА. ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХЭД ХУУЛЬ БУСААР, ХЭТРҮҮЛЭН ХАЛДАХ ЭРСДЭЛИЙГ ШИНЖЛЭХ НЬ

Хууль хэрэгжүүлэгчийн мэдлэг, ур чадвар ба ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэйгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан халдашгүй байх эрхэд халдах ажиллагааг

хууль бусаар буюу хэтрүүлэн явуулах эрсдэлийг прокурортой хийсэн ярилцлага, шүүхийн шийдвэрт үндэслэн авч үзлээ.

Хяналтын прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

- Нэгжлэг хийх, эд мөрийн баримт хураан авах, орон байранд нэгжлэг хийх, мэдээлэл баримт бичиг гаргуулан авах, хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах зэрэг зөвшөөрөл авах ажиллагаанууд хамгийн түгээмэл хэрэглэгддэг.
- Дээрх ажиллагаануудад мөрдөгчөөс зохих шаардлага, хангалттай үндэслэл зэргийг саналд тусгасан байвал хэргийг нь уншиж танилцсаны үндсэн дээр зөвшөөрөл олгодог. Харин эсрэгээрээ хэрэг шийдвэрлэхэд ямар нэгэн байдлаар ач холбогдолгүй, зорилго тодорхойгүй байгаа нөхцөлд зөвшөөрөл олгодоггүй.

Тухайлбал, нэгжлэг хийхээр санал гаргаж ирүүлэхдээ нэгжлэгийг хүний биед эсхүл орон байр, бусад газрын алинд нь хийх талаараа тусгалгүй, “Нэгжлэг” хийх гэж ерөнхий байдлаар тусгадаг, эсхүл сэжиглэж буй этгээдийн орон байранд гэх боловч хаягийг нь саналд тусгадаггүй гэх мэт зөрчил гаргадаг.

- Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах санал гаргах зөвшөөрөл гэхэд дотроо хэд хэдэн төрөлтэй. Тухайлбал, иргэний бүртгэлийн эрх бүхий байгууллагаас эд хөрөнгийн болон бусад бүртгэлтэй холбоотой лавлагааг авахдаа тухайн этгээдийн регистр зөв биш, овог нэр алдаатай байснаас өөр хүний талаарх мэдээлэл ирэх, эсвэл ирэхгүй байх тохиолдол гардаг.
- Мөн хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах ажиллагаанд тухайн хүн нь зөвшөөрсөн байтал зөвшөөрөл авах талаар санал гаргаж ирүүлсэн тохиолдол мөн гарсан.
- Орон байранд нэгжлэг хийхдээ хайсан зүйлээ олсон боловч гэрт байгаа бүх зүйлийг дуустал нэгжлэг хийсэн тохиолдол гарч байсан. Үүнийхээ үндэслэлийг мөрдөгч нь уг этгээд олон удаагийн хулгайн гэмт хэрэг үйлдэж байсан тул прокурорын зөвшөөрөлд заасан бурхнаас өөр зүйлс хайсан гэж тайлбарласан. Тухайн ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зорилгод нийцэж байгаа гэж үзэж нотлох баримтаар тооцсон.
- Мөн прокуророос нэгжлэг хийх зөвшөөрлийг нэр зааж буюу санал гаргасан мөрдөгчид олгосон байхад тухайн зөвшөөрлөөр өөр мөрдөгч орон байранд нэгжлэг хийсэн тохиолдол гарч байсан. Мөрдөгч энэ талаарх үндэслэлээ тайлбарлахдаа “Тасгийн даргын тушаалаар биднийг хамтарч мөрдөхийг үүрэг болгосон тул болох байх гэж бодоод нэгжлэг хийсэн” гэдэг.
- Мөрдөгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулсан боловч мөн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүчинтэйд тооцуулах саналаа 24 цагийн дотор биш 48 цагийн дотор мэдэгдсэн, ирүүлсэн тохиолдол их гардаг. Энэ нь тухайн нотлох баримт нь хүчингүйд тооцогдох үндэслэл болдог. Гэтэл тухайн хэргийн хувь заяаг шийдвэрлэх нотлох баримт байх нөхцөлд тухайн ирүүлсэн саналыг үл харгалзан хүчинтэйд тооцохоос өөр аргагүй нөхцөл байдал заримдаа хүрдэг. Энэ талаарх мэдлэг мөрдөгч нарт бараг байдаггүй.
- Эд мөрийн баримтыг хураан авсныхаа дараа зөвшөөрөл авахаар санал гаргадаг. Зүй нь саналыг урьдчилж ирүүлэх ёстойг ойлгодоггүй, хэрэв зөвшөөрөлгүй хураан авсан бол түүнийгээ хүчинтэйд тооцуулах ёстойг мөн мэддэггүй. Энэ талаар мөрдөгч нарт анхааруулж шаардлага бичсээр байдаг боловч энэ талаар Цагдаагийн газрын эрх бүхий удирдлагууд нь анхаарч, мөрдөгчийг сургах талаар дорвитой арга хэмжээ авдаггүй, хуулиа бүрэн судалдаггүй.

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 741 дүгээр цагаатгах тогтоолоос

“...Шүүх хуралдаанд шүүгдэгч Ж.О-ын өмгөөлөгчөөс хэрэгт авагдсан ‘нууц ажиллагааны магадалгаа’-г ...ашиг сонирхлын зөрчилтэй мөрдөгч нар хууль бусаар нөхөн үйлдсэн нь нотлох баримт бэхжүүлэх, цуглуулах хуульд заасан журмыг зөрчиж авагдсан тул нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломжгүй гэж тайлбарласан ба хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаас үзэхэд гар утсыг нууцаар чагнах ажиллагаа нь хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаагүй байх тул нотлох баримтад үнэлэх үндэслэлгүй байна.

Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2-т заасан “Хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтооно” гэсэн заалтыг зөрчжээ.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдаанаар нотолбол зохих байдал буюу шүүгдэгч нарт холбогдох эрүүгийн хэрэгт хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн баримтаар хангалттай нотлогдоогүйн улмаас гэм буруутайд тооцоход эргэлзээ гарч байх тул шүүгдэгч Ж.О-ыг хээл хахууль авсан, П.А-ыг хахууль өгсөн гэмт хэргийг тус тус үйлдсэн нь нотлогдоогүй үндэслэлээр цагаатгах нь зүйтэй гэж үзлээ.

Хяналтын прокурортой хийсэн ярилцлага, халдашгүй байх эрхэд халдах ажиллагааг хууль шүүхийн шийдвэрийн үндэслэлээс үзэхэд, бусаар буюу хэтрүүлэн явуулах эрсдэлд хүргэж мөрдөгчийн мэдлэг, ур чадварын түвшин нь болохоор байна.

ДУГНЭЛТ

Хүний халдашгүй байх эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд заасан бөгөөд энэ нь тус эрхийн талаарх олон улсын стандарт юм. Энэ зүйлийг НҮБ-ын Хүний эрхийн хорооноос дэлгэрүүлэн тайлбарлаж Ерөнхий зөвлөмж гаргасан бөгөөд түүнийг тус Хорооноос гомдол хянан хэлэлцэж гаргасан олон шийдвэртэй тухай бүр баталгаажуулсан байна. Эдгээр тайлбар, шийдвэрт хүний халдашгүй байх эрхэд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар халдахаас сэргийлэхийн тулд тэрхүү халдлага нь хууль ёсны байх, зайлшгүй шаардлагатай байх, тохиромжтой байх гэсэн гурван шаардлагыг нэгэн зэрэг хангаж байх ёстойг нотолжээ. Хүний халдашгүй байх эрхэд халдах зөвшөөрөл нь энэхүү гурван шаардлагыг хангуулах буюу түүний биелэлтэд хяналт тавихад чиглэнэ.

Монгол Улсын хувьд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын оролцогч улс болохын хувьд Монгол Улсын Үндсэн хуульд хүний халдашгүй байх эрхийг баталгаажуулжээ. Харин Үндсэн хууль батлагдсанаас хойш үйлчилсэн Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудад хүний халдашгүй байх эрхэд халдах ажиллагааны зөвшөөрлийн тогтолцоог харилцан адилгүй зохицуулжээ. Нийтлэг буюу уламжлагдсаар буй зохицуулалт бол мөрдөгчийн зүгээс халдашгүй байх эрхэд халдах зарим ажиллагааны талаар прокурорт мэдэгдэх, прокуророос зөвшөөрөл авах зохицуулалт юм. 2017 оноос үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд халдашгүй байх эрхэд халдах бүх ажиллагаанд прокурорын

зөвшөөрлийг авахаар тусгаснаараа өмнөх хуулиудын зохицуулалтаас дэвшилттэй болжээ. Харин халдашгүй байх эрхэд халдах ажиллагаанд шүүхийн зөвшөөрлийг авахгүй байх зохицуулалт өөрчлөгдөөгүй хэвээр үргэлжилж байна.

Эдгээр зохицуулалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар тогтоосон хүний халдашгүй байх эрхэд хуульд заасны дагуу халдахад баримтлах олон улсын зарчмуудад хэсэгчилсэн байдлаар нийцэж байна. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт нь “хууль зүйн үндэслэлтэй байх”, “гомдол гаргах нөхцөлөөр хангах” дэд зарчимд нийцэж байна. Харин тус хуулийн зохицуулалтыг “хууль ёсны зорилготой байх”, “эрх мэдэл бүхий шүүхийн хяналтад байх”, “зайлшгүй шаардлагатай байх”, “тохирохуйц байх”, “пропорциональ буюу тэнцүү чанартай байх”, “зүй ёсны ажиллагаа явуулах” гэсэн дэд зарчмуудад, Эрүүгийн хуулийн зохицуулалтыг “хууль бус халдлагын эсрэг баталгаа, эрх зүйн үр нөлөөтэй хамгаалалт бүрдүүлэх” зарчимд тус тус бүрэн нийцүүлэх шаардлагатай.

Ийнхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт хүний халдашгүй байх эрхэд хуульд заасны дагуу халдахад баримтлах олон улсын зарчмуудтай бүрэн уялдуулаагүй байдал нь халдашгүй байх эрхэд халдах ажиллагааг хууль бусаар буюу хэтрүүлэн явуулах бодит эрсдэлийг бий болгож байна. Энэ нь мөрдөгч, прокуророос гаргах эрх зүйн актын эргэлзээтэй байдал, мөрдөгчийн мэдлэг, ур чадварын түвшнээр илэрч байна.

ЗӨВЛӨМЖ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд дараах агуулга бүхий өөрчлөлт оруулах санал гаргаж байна. Үүнд:

1. “Хүний биед үзлэг хийх” гэх гарчиг бүхий 23.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Энэ хуульд заасан бусад аргаар нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа явуулсан ч үр дүнд хүрээгүй тохиолдолд хүний биед үзлэг хийж болно” гэж өөрчлөн найруулах.
2. “Эд мөрийн баримт хураан авах” гэх гарчиг бүхий 24.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Мөрдөгч хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг байна гэх хангалттай үндэслэл байвал эд мөрийн баримтыг прокурорын зөвшөөрлөөр түр хураан авна” гэж өөрчлөн найруулах.
3. “Хүний биед үзлэг хийх” гэх гарчиг бүхий 23.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Хүний биед Эрүүгийн хуульд заасан хүнд гэмт хэргийн ул мөр, онцлог шинж тэмдэг байгаа, эсхүл Эрүүгийн хуульд заасан хүнд

гэмт хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг тухайн хүн биедээ авч яваа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа бол түүнийг илрүүлэх зорилгоор хүний биед үзлэг хийнэ” гэж өөрчлөн найруулах.

4. “Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах” гэх гарчиг бүхий 26.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Мөрдөгч Эрүүгийн хуульд заасан хүнд гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл Эрүүгийн хуульд заасан хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр дараах ажиллагаа явуулна” гэж өөрчлөн найруулах.
5. “Харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох” гэх гарчиг бүхий 26.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Мөрдөгч Эрүүгийн хуульд заасан хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээ, баримт байна гэх хангалттай үндэслэл байвал прокурорын зөвшөөрлөөр дараах арга хэмжээг авч болно” гэж өөрчлөн найруулах.
6. “Ажиглалт явуулах” гэх гарчиг бүхий 26.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Мөрдөгч Эрүүгийн хуульд заасан хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоох зорилгоор тодорхой нутаг дэвсгэр, олон нийтийн газарт хүн, объектод ердийн болон нууц ажиглалт явуулна” гэж өөрчлөн найруулах.
7. “Прокурорын зөвшөөрөл” гэх гарчиг бүхий 22.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.7-г “ажиллагааны явцад хүний эрхийг хангах тусгайлсан арга хэмжээ” гэж өөрчлөн найруулах.
8. “Мөрдөн шалгах ажиллагаа” гэх гарчиг бүхий 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг “Мөрдөн шалгах ажиллагаа нь прокурорын болон шүүгчийн зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөгчийн бие даан явуулах мөрдөн шалгах ажиллагаанаас бүрдэнэ” гэж өөрчлөн найруулах.
9. “Мөрдөн шалгах ажиллагаа” гэх гарчиг бүхий 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг “Мөрдөгч үзлэгийг нууцаар хийх, нэгжлэг хийх, эд зүйл, баримт бичиг хураан авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах, хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах, оршуулсан цогцсыг гарган шинжлэх, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, хяналттай хүргэлт, хяналтын худалдан авалт, мөрдөн шалгах нууц туршилт, нууц ажиглалт, таньж олуулах ажиллагааг илээр хийхийг прокурорын зөвшөөрлөөр, нууцаар хийхийг шүүхийн зөвшөөрлөөр явуулна” гэж өөрчлөн найруулах.
10. “Мөрдөн шалгах ажиллагаа” гэх гарчиг бүхий 22.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг “Мөрдөгч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан ажиллагааг илээр явуулах саналыг прокурорт, нууцаар явуулах саналыг шүүхэд хүргүүлнэ” гэж өөрчлөн найруулах.
11. “Мөрдөн шалгах ажиллагаа” гэх гарчиг бүхий 22.1 дүгээр зүйлд “11.Мөрдөгч үзлэг, нэгжлэг хийх, хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах, эд мөрийн баримт хураан авах, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, ажиглалт явуулах ажиллагааны дараа үүссэн сөрөг үр дагаврыг даруй арилгах арга хэмжээ авч, энэ талаар тэмдэглэлд тусгана” гэж нэмэх.

Эрүүгийн хуульд дараах агуулга бүхий өөрчлөлт оруулах санал гаргаж байна. Үүнд:

12. Эрүүгийн хуулийн 13.7 дугаар зүйлийн гарчгийг “Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх, хүний биед үзлэг хийх” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийг “Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний бие, хүний эд зүйл, тээврийн хэрэгсэлд нэгжлэг хийсэн, үзлэг хийсэн, эд хөрөнгө битүүмжилсэн, хураан авсан бол...” гэж тус тус өөрчлөн найруулах.